

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ 3 ДУГААР ХУРАЛДААН**

Хуралдаан 2017 оны хоёрдугаар сарын 03-ны 09 цаг 15 минутад эхэлж, 11 цаг 18 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын даргын өрөөнд болж, нийт 2 цаг 03 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	Ж.Түмэндэлгэрийн өргөдлийг хянан шийдвэрлэсэн дүнгийн тухай	“Ж.Түмэндэлгэрийг ажлаас чөлөөлөх тухай” аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2016 оны 11 сарын 22-ны өдрийн Б/54 тоот тушаалыг эс зөвшөөрч Хөгжлийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтнээр ажиллаж байсан Ж.Түмэндэлгэрийн Төрийн албаны зөвлөлөөс тус салбар зөвлөлд шилжүүлсэн гомдлыг хянан шалгасан Маргаан хянан шийдвэрлэх комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэж, шийдвэрийг Ж.Түмэндэлгэрт хүргүүлэхээр болов.
2	Л.Мөнхзулын өргөдлийг хянан шийдвэрлэсэн дүнгийн тухай	Л.Мөнхзулын Төрийн албаны зөвлөлийн тус аймгийн салбар зөвлөлд гаргасан гомдлыг хянан шалгасан Маргаан хянан шийдвэрлэх комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэж, Л.Мөнхзулд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.
3	Төрийн жинхэнэ албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох, ахиулах тухай	Нэр бүхий 55 төрийн жинхэнэ албан хаагчдад албан тушалын зохих зэрэг дэвийг шинээр олгох , ахиулах асуудлыг аймгийн Засаг даргад санал болгон уламжлах тогтоол гаргахаар шийдвэрлэв.
4	Хулд сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны дарга, төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын дүнгийн тухай	Хулд сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга, төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулалтад тэнцсэн Жүгдэр овогтой Эрдэнэчимэг, Чагнаадорж овогтой Түвшинбаяр, Энхтайван овогтой Хонгорзул, Чойжилсүрэн овогтой Хүүхэнбаатар нарыг тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан тул төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцийн жагсаалтад бүртгэж, ажлын байрны шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа Жүгдэр овогтой Эрдэнэчимэгийн талаарх дүгнэлтийг баталж, Хулд сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга, төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалд нэрийг дэвшүүлэв.
5	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхөх тухай	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын 20 сул орон тоог нөөцөөс нөхөх зард зарлуулахаар ТАЗ-д хүргүүлэхээр болов.
6	Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны даргын албан тушаалд нэр дэвшүүлсэн Ч.Батхуягт дүгнэлт гаргах тухай	Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны даргын албан тушаалд нэр дэвшүүлж буй Чулуунбат овогтой Батхуягийн дүгнэлтийг баталж, тухайн албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг Дэлгэрхангай сумын Засаг даргын Тамгын газрын даргад хүргүүлэхээр болов.

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА